



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Заг сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/69НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Д.Цэцэгмаа Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Агуулга

1. Аудитын гэрчилгээ /эх хувь/.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Төлбөрийн акт.....	16
4.2 Албан шаардлага.....	16
4.3 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,

Баянхонгор аймаг, 64101

Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24

№

2193

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАГ
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д. ОЮУНТӨГС ТАНАА

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Заг сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Заг сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>43,755,910.00</u>	<u>46,457,300.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	43,755,910.00	46,457,300.00
351	Түүхий эд материал	43,425,910.00	46,020,800.00
35110	Тусгай зориулалттай материал	43,425,910.00	44,256,800.00
35130	Эм боох материал	00.00	1,764,000.00
354	Хангамжийн материал	330,000.00	436,500.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	6,500.00
35420	Аж ахуйн материал	330,000.00	430,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>400,240,281.15</u>	<u>385,965,875.25</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	400,240,281.15	385,965,875.25
392	Биет хөрөнгө	392,660,281.15	378,385,875.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	393,692,674.00	393,692,674.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-18,424,427.76	-27,636,641.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	23,983,500.00	23,983,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,476,260.32	-15,313,280.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,534,207.80	15,534,207.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,849,412.57	-12,834,584.23
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,095,636.00	5,095,636.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,895,636.00	-4,495,636.00
39217	Ном	00.00	360,000.00
393	Биет бус хөрөнгө	7,580,000.00	7,580,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,580,000.00	7,580,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>443,996,191.15</u>	<u>432,423,175.25</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>443,996,191.15</u>	<u>432,423,175.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	443,996,191.15	432,423,175.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	541,987,288.00	541,987,288.00
51101	Өмч: - төрийн	541,987,288.00	541,987,288.00
512	Хуримтлагдсан үр дүн	-102,945,074.75	-114,518,090.65
51210	Өмнөх үеийн үр дүн	-102,945,074.75	-102,945,074.75
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-11,573,015.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,953,977.90	4,953,977.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>443,996,191.15</u>	<u>432,423,175.25</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	216,405,162.00	202,623,351.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,899,462.00	363,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,899,462.00	363,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,899,462.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,899,462.00	00.00
120018	Үнэ төл		363,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	199,505,700.00	202,632,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	182,457,200.00	185,583,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	182,457,200.00	185,583,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17,048,500.00	16,676,451.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,048,500.00	16,676,451.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	204,425,810.53	214,196,366.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	204,425,810.53	214,196,366.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	191,757,645.38	200,524,514.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,006,377.85	137,226,290.51
210101	Үндсэн цалин	130,006,377.85	137,226,290.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,004,057.00	17,286,626.80
210201	Тэтгэврийн даатгал	10,605,489.10	11,779,172.25
210202	Тэтгэмжийн даатгал	1,330,947.08	1,321,455.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,044,597.66	1,116,099.87
210204	Ажилгүйдлийн даатгал	257,529.88	278,999.02
210205	Эрүүл мэндийн даатгал	2,765,493.28	2,790,899.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,176,808.00	16,176,451.00
210301	Гэрэл, цахилгаан	872,808.00	598,951.00
210302	Түлш, халаалт	14,446,500.00	15,427,500.00
210303	Цэвэр, бохир ус	857,500.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,981,999.00	9,000,000.00
210401	Бичиг хэрэг	990,600.00	250,000.00
210402	Тээвэр, шатахуун	874,000.00	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	871,200.00	871,200.00
210404	Ном, хэвлэл	31,400.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	168,900.00	240,000.00

Заг сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	493,500.00	818,500.00
210408	Бараа материал акталсны зардал	1,552,399.00	4,677,300.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	00.00	143,000.00
2105	Нормативт зардал	8,057,092.00	3,782,630.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,229,300.00	245,300.00
210502	Хоол, хүнс	6,827,792.00	3,255,930.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	281,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,096,300.00	646,300.00
210604	Урсгал засвар	1,096,300.00	646,300.00
2107	Томилолт, зочны зардал	358,600.00	58,600.00
210702	Дотоод албан томилолт	358,600.00	58,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,002,300.00	1,192,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	752,300.00	602,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,074,111.53	15,155,315.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	653,000.00	520,910.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,421,111.53	14,634,405.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,668,165.15	13,671,852.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,662,800.00	6,062,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,662,800.00	6,062,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,545,192.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,545,192.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,460,173.15	7,609,052.69
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,460,173.15	7,609,052.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>11,979,351.47</u>	<u>-11,573,015.90</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>11,979,351.47</u>	<u>-11,573,015.90</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>199,505,700.00</u>	<u>202,260,351.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>199,505,700.00</u>	<u>202,260,351.00</u>

Заг сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	182,457,200.00	185,583,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	182,457,200.00	185,583,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17,048,500.00	16,676,451.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,048,500.00	16,676,451.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	197,505,700.00	201,900,351.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	197,505,700.00	201,900,351.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	184,837,534.85	188,228,498.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,006,377.85	137,226,290.51
210101	Үндсэн цалин	96,151,272.47	105,208,000.00
210102	Нэмэгдэл	15,872,494.73	15,639,541.34
210104	Урамшуулал	17,332,610.65	16,378,749.17
210105	Гэрээт ажлын хөлс	650,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,004,057.00	17,286,626.80
210201	Тэтгэврийн даатгал	10,584,645.00	11,779,172.25
210202	Тэтгэмжийн даатгал	1,333,500.00	1,321,455.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,057,112.00	1,116,099.87
210204	Ажилгүйдлийн даатгал	266,800.00	278,999.02
210205	Эрүүл мэндийн даатгал	2,762,000.00	2,790,899.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,503,308.00	16,176,451.00
210301	Гэрэл, цахилгаан	872,808.00	598,951.00
210302	Түлш, халаалт	14,399,000.00	15,427,500.00
210303	Цэвэр, бохир ус	231,500.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,433,100.00	4,286,200.00
210401	Бичиг хэрэг	1,038,100.00	256,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	871,200.00	871,200.00
210404	Ном, хэвлэл	31,400.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	273,900.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	718,500.00	918,500.00
2105	Нормативт зардал	13,641,192.00	10,546,630.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,229,300.00	2,009,300.00
210502	Хоол, хүнс	6,827,792.00	3,255,930.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,584,100.00	5,281,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,096,300.00	646,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,096,300.00	646,300.00
2107	Томилолт, зочны зардал	358,600.00	58,600.00
210702	Дотоод албан томилолт	358,600.00	58,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,002,300.00	1,192,300.00

Заг сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	752,300.00	602,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,792,300.00	809,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,792,300.00	809,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,668,165.15	13,671,852.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,662,800.00	6,062,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,662,800.00	6,062,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,545,192.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,545,192.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,460,173.15	7,609,052.69
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,460,173.15	7,609,052.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,000,000.00</u>	<u>360,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>2,000,000.00</u>	<u>360,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>2,000,000.00</u>	<u>360,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>2,000,000.00</u>	<u>360,000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,000,000.00	360,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-2,000,000.00</u>	<u>-360,000.00</u>
7	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>00.00</u>	<u>00.00</u>
9	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>00.00</u>	<u>00.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	541,987,288.00	4,953,977.90	-114,924,426.22	432,016,839.68
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,979,351.47	11,979,351.47
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	541,987,288.00	4,953,977.90	-102,945,074.75	443,996,191.15
D01	2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	541,987,288.00	4,953,977.90	-102,945,074.75	443,996,191.15

Заг сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	541,987,288.00	4,953,977.90	-102,945,074.75	443,996,191.15
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-11,573,015.90	-11,573,015.89
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	541,987,288.00	4,953,977.90	-114,518,090.65	432,423,175.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	203,483,900.00	194,651,298.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	203,483,900.00	194,651,298.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	197,421,100.00	188,588,498.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	141,238,500.00	137,226,290.51
210101	Үндсэн цалин	105,208,400.00	105,208,000.00
210102	Нэмэгдэл	15,715,800.00	15,639,541.34
210104	Урамшуулал	20,314,300.00	16,378,749.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,712,200.00	17,286,626.80
210201	Тэтгэврийн даатгал	11,782,700.00	11,779,172.25
210202	Тэтгэмжийн даатгал	1,482,300.00	1,321,455.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,186,000.00	1,116,099.87
210204	Ажилгүйдлийн даатгал	296,400.00	278,999.02
210205	Эрүүл мэндийн даатгал	2,964,800.00	2,790,899.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,400,000.00	16,176,451.00
210301	Гэрэл, цахилгаан	1,822,500.00	598,951.00
210302	Түлш, халаалт	15,427,500.00	15,427,500.00
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,149,200.00	4,646,200.00
210401	Бичиг хэрэг	256,500.00	256,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,352,800.00	871,200.00
210404	Ном, хэвлэл	381,400.00	360,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	918,500.00	918,500.00
2105	Нормативт зардал	13,214,900.00	10,546,630.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,029,300.00	2,009,300.00
210502	Хоол, хүнс	5,904,200.00	3,255,930.00

Заг сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,281,400.00	5,281,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	646,300.00	646,300.00
210604	Урсгал засвар	646,300.00	646,300.00
2107	Томилолт, зочны зардал	58,600.00	58,600.00
210702	Дотоод албан томилолт	58,600.00	58,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,192,300.00	1,192,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	602,300.00	602,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	809,100.00	809,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	809,100.00	809,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	606,280.00	606,280.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,062,800.00	6,062,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,062,800.00	6,062,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	203,483,900.00	194,651,298.31
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	185,583,900.00	177,974,847.31
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	185,583,900.00	177,974,847.31
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,900,000.00	16,676,451.00
132001	Орон нутгийн төсвөөс	17,900,000.00	16,676,451.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13.00	13.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	13.00	13.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	08.00	08.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	05.00	05.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Заг сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Заг сумын Цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Цэцэрлэгийн эрхлэгч Д.Оюунтөгс нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч У.Сүхбаатар нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Заг сумын Цэцэрлэг нь тайлант онд цаасан урлал болон ардын хөлөгт тоглоомоор дамжуулж хүүхдийн оюун ухаан, сэтгэхүйг хөгжүүлэх, зөв монгол хүүхэд болгон төлөвшүүлэх зорилт дэвшүүлэн, хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Заг сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөх холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Заг сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Заг сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 204425.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3066.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн

Заг сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2299.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 2409.7 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Заг сумын Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 432,423.2 мянган төгрөг болж өмнөх оноос 11,573.0 мянган төгрөгөөр буюу 2,6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	43,755.9	46,457.3	2,701.4
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	43,755.9	46,457.3	2,701.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	400,240.3	385,965.9	(14,274.4)
Үндсэн хөрөнгө	446,336.0	446,696.0	360.0
Хуримтлагдсан элэгдэл	(46,095.7)	(60,730.1)	(14,634.4)
Нийт хөрөнгө	443,996.2	432,423.2	(11,573.0)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	443,996.2	432,423.2	(11,573.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	443,996.2	432,423.2	(11,573.0)

Эх сурвалж: 2021 оны санхүүгийн тайлангаас

Бараа материалын дансны үлдэгдэл 46,457.3 мянган төгрөг болж 2,701.4 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 830.9 мянган төгрөгөөр, эм, ороох боох материалын дансны үлдэгдэл 1,764.0 мянган төгрөгөөр тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 446,696.0 мянган төгрөг болж 360.0 мянган төгрөгөөр өссөн нь ном худалдаж авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 432,423.2 мянган төгрөг болж 11,573.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 251,755.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 251,755.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Заг сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 15,731.1 мянган төгрөгөөр бууруулж 236,024.4 мянган төгрөгөөр батлагдсан ба 2021 оны 07 дугаар сард сумын Засаг даргын А/106 тоот захирамжаар төсөвт зохицуулалт хийгдэж 203,483.9 мянган төрөг болж 32,540.5 мянган төгрөг буюу 13,8 хувиар буурч батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 203,483.9 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 185,583.9 мянга, орон нутгийн төсвөөс 17,900.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 177,974.8 мянга, орон нутгийн төсвөөс 16,676.4 мянга нийт 194,651.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 194,651.3 мянган төгрөгийг зарцуулж 7,609.1 мянган төгрөг буюу 4,3 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 12,235.0 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 194,651.3 мянган төгрөг буюу 95,7 хувьтай байгаа нь байр ашиглалттай тогтмол зардлыг 1,223.5 мянга, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 3,012.2 мянга, хүүхдийн хоолны зардал 11,098.3 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Энхтуяа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилт 27 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 84.0%-тай гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 214,196.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 9,670.6 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин хөлс, нэмэгдэл урамшил, хангамж, бараа материалын зардал өсөж, нормативд зардал хөл хориотой холбоотой буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс тухай бүр оруулах цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ өссөн дүнгээр 38,166.1 мянган төгрөгийн 2 мэдээлэл, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгааны тайлбарын 9-р сарын 14,725.1 мянган төгрөгийн 1 мэдээлэл, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 40,466.3 мянган төгрөгийн 2 мэдээлэл, бусад 7, нийт 93,357.5 мянган төгрөгийн 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 177,974.8 мянга, орон нутгийн төсвөөс 16,676.4 мянга нийт 194,651.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 194,651.3 мянган төгрөгийг зарцуулж 7,609.1 мянган төгрөг буюу 4,3 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 1,223.5 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 19,428.4 мянган төгрөг батлагдсан ба батлагдсан төсвийн 20 хувь нь 3,885.7 мянган төгрөг байна. Тус онд 2021 оны 7-р сард сумын Засаг даргын А/106 тоот захирамжаар хийгдсэн зохицуулалтаар 2,028.4 мянган төгрөгийг хасаж тодотгосон, тодотгосон төсвөөс 1,223.5 мянган төгрөгийн, нийт 3,251.9 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай нийцэж байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 40,466.3 мянган төгрөгийн хүүхдийн хоол худалдан авах ажиллагааг сумын ЗДТГ зохион байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2746.3 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрч, 371.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1803.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 571.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 .Төлбөрийн акт

4.1.1. Нягтлан бодогчийн 1,3-р улирлын үр дүнгийн урамшуулал цалинг үндсэн орон тооны ажилтны цалингаас бодож 265.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсалтаар батлагдсан” Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”- 4.2. Энэ журмын 4.1-д заасан албан хаагч гэдэгт сургалтын байгууллагын төсвөөс цалинждаг орон тооны ажилтан хамаарна. 4.5.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно.гэснийг зөрчсөн нь санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнаар буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.1.2. 2021.12.20-ны өдөр Өнөөгийн Баянхонгор сонины газарт /36*4500/ сонины үнэд 106.2 мянган төгрөгийг төсвөөс төлөөд суутган тооцоо хийгээгүй зардалд бичсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Холбогдох ажилтнуудаар буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

4.2. Албан шаардлага

4.2.1.Ажилтнуудын цалингийн санг НДХ-т дутуу мэдээлсэн 1,254.5 мянган, илүү мэдээлсэн 549.0 мянган, нийт 1,803.5 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ажилчдын 2021 оны 1.803,5 мянган төгрөгийн цалинг залруулж мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.3.Зөвлөмж

4.3.1. Цалингийн зардлаас ажил олгогчийн төлөх 485.6 мянган төгрөгийг төлөөд тохируулах бичилтээр цалингийн зардалд хаасан, 12 дугаар сарын цалингаас суутгасан ҮЭТ-ын 86.0 мянган төгрөгийг төлөөгүй, өглөгөөр тусгаагүй, цалингийн зардлыг дутуу илэрхийлсэн нь санхүүгийн тайлагналын “Ангилал”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв бүртгэж байх

4.3.2 Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс 93,357.5 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.4, 6.4.5 дахь хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Заг сумын Цэцэрлэг	5	2,746.3	0	0	2	371.2	1	1,803.5	2	571.6

_____оОо_____